


Баян хүн, ядуу Лазар хоёрын тухай өгүүллэг I Болсон бодит явдал гэж авч үзвэл...

Баян хүн, ядуу Лазар хоёрын тухай Есүсийн ярьсан алдартай өгүүллэгийг итгэгчид ихэвчлэн буруу ойлгодог гэхэд хилсдэхгүй. Учир нь тэд энэ өгүүллэгийг болсон явдал гэж үздэг. Энэ өгүүллэгээс л там ямар байх тухайд төсөөлөл авч, тамын тухай номлодог пастор олон бий. Энэ хэсгийг тэд тамын бодитойг нотлох хамгийн том баталгаа ч гэж үздэг. Нэгэнт тамыг үнэхээр байдаг гэж заах нь түгээмэл учраас тамын тухай бодохоос ч жийрхэх хүсэл бидэнд төрдөг ч энэ сэдвийг маш нухацтай авч үзэх ёстой. Энэ нь бидний хайртай бүх хүмүүсийн мөнхийн хувь заяатай нягт холбоотой учраас бид Есүсийн ярьсан өгүүллэгийг тунгаан бодож зөв тайлж, зөв ойлгох нь нэн чухал. Тэгсэн цагт Есүсийн энэ үг ч гэсэн үнэхээр гайхалтай гүн гүнзгий утгыг агуулсан болохыг олж харахдаа бид айдасгүй байж, Их Эзэнээ үнэн сэтгэлээс бишрэн магтахад хүрэх болно.

«Лук» номын 16-р бүлэг

19 Нэгэн баян хүн байжээ. Тэр нил ягаан өнгийн нарийн нэхсэн маалинган хувцас өмсөж, өдөр бүр найрлан цэнгэдэг байв. 20 Яр

шарханд баригдсан Лазар гэгч нэгэн ядуу эр хаалгыг нь сахин хэвтэж, 21 мөнөөх баяны ширээнээс унасан өвдөл цөвдлийг нь идэхсэн хэмээн хүсдэг байжээ. Хажуугаар нь ноход ирж, шархыг нь долоодог байв.





22 Ядуу эр үхсэнд тэнгэр элч нар түүнийг авч Абрахамын өвөр дээр тавьжээ. Баян нь ч үхсэнд түүнийг оршуулав.

23 Тийнхүү тэр Үхэгсдийн оронд тарчлан байхдаа хараагаа дээшлүүлж, тэртээд байгаа Абрахамыг болон түүний өвөр дэх Лазарыг харав. 24 Тэгээд тэр "Абрахам эцэг ээ, намайг өршөөгөөч. Лазарыг нааш нь явуулаач. Тэр хурууныхаа үзүүрийг усанд дүрээд хэлийг минь сэрүүцүүлэг. Би энэ галд амь тэмцэн зовж байна" гэж хашхирахад 25 Абрахам "Хүү минь, чи амьдралынхаа туршид сайн сайхан зүйлээ хүлээн авч байхад Лазар ч тэрчлэн муугаа авсныг санаач. Харин одоо тэр энд тайтгарч, чи тэнд зовж байна. 26 Энэ бүхнээс гадна, эндээс наана чинь очих, наанаас чинь энд ирэхийг хүсэгчдийн хэн ч ирж, очиж үл чадах тийм гүн ангал чи бидний дунд тогтжээ" гэхэд 27 тэр "Эцэг минь, тэгвэл түүнийг миний эцгийн гэрт илгээхийг би танаас гуйя. 28 Би таван дүүтэй. Энэхүү тарчлалын газар тэднийг ирүүлэхгүйн тулд Лазар тэдэнд сануулаг" гэж хэлжээ.

29 Харин Абрахам "Тэдэнд Мосе ба Эш үзүүлэгчид байгаа. Дүү нар чинь тэднийг сонсог" гэхэд 30 тэр "Үгүй, Абрахам эцэг минь, үхэгсдээс хэн нэг нь тэдэн рүү явбал тэд гэмших болно" гэв. 31 Харин тэр түүнд "Хэрэв тэд Мосе ба Эш үзүүлэгчдийг сонсдоггүй юм бол үхэгсдээс хэн нэг нь амилсан ч тэд үнэмшихгүй биз дээ" гэжээ гэв. (Лук 16:19-31)

"Боломжтой бол шууд утгаар нь ойлгож ав" гэсэн Библийг зөв ойлгоход тус болохуйц нэгэн чухал зарчим бий.



Тийм учраас юуны өмнө ихэнх итгэгчийн үздэгчлэн тус өгүүллэгийг болсон явдал гэж үзвэл: Баян хүн, Лазар хоёр энэ дэлхийд амьдраад тус бүрдээ нас барж нэг нь диваажин, нэг нь тамд очсон бодит түүхэн үйл явдал гэсэн утгаар шинжиж үзэх хэрэгтэй болно. Хэрвээ болсон явдал мөн юм бол энэ өгүүллэгт гардаг бүх юм бодит үнэн, яг бичсэний дагуу тохиолдсон байх ёстой. Тэгвэл ямар зорилгоор Есүс энэ өгүүллэгийг ярьсан юм бол? Бидний амьдралд тэдний түүх ямар хамаатай болохыг эргэцүүлж үзвэл гол утга нь “бид хэрхэн баян хүн шиг тамд оролгүй ядуу Лазар шиг диваажинд¹ орох вэ?” гэсэнд орших буй за.

*Боломжтой
бол шууд
утгаар нь
ойлгож ав.*

Эхний ээлжинд энэ өгүүллэгийг хэсэг хэсгээр нь авч үзээд болсон явдал байж болох уу гэсэн талаас шинжиж үзье.

¹ Энэ судалгаанд “диваажин” гэсэн үгийг монголчуудын хэрэглээний дагуу “тамын эсрэг болох газар” гэсэн утгаар хэрэглэсэн. Библид гардаг “диваажин” (G3857, Лук 23:43) перс гаралтай үг бөгөөд “цэцэрлэг” гэсэн утгатай (H6508). Энэ үг «Шинэ гэрээ»-нд иш татагддаг, «Хуучин гэрээ»-ний грек орчуулганд (Септуагинта) анх Ээдэн цэцэрлэгийг хэлсэн (Эхлэл 3:2 г.м.). Ирээдүйн 1000 жилийн Хаант Улс ба үүний дараах шинэ газар дэлхий яг тийм сайхан, цэцэглэсэн диваажин байх болно (Исаиа 35; Илчлэл 2:7; 22:2; Езекиел 47:12). Диваажин тэнгэрийн улс биш, шинэчлэгдсэн дэлхий гэсэн үг. Энэ нь mongoltoli.com-д өгсөн “Хүний аж төрөхөд ая тухтай нөхцөл бүрдсэн орчин газар, жаргалын орон” гэсэн монголчуудын шилжсэн утгын хэрэглээнд нийцэх юм. Харин Паул итгэгчдийг “үүлэн дунд өргөгдөж”, “тэнгэрлэг оршихуйд суулгагдах” болно гэж бичсэн (1 Тесалоник 4:14-17; Эфэс 2:6). Олон итгэгч дэлхий дээрх диваажинг тэнгэр дээрх улстай хольж хутгадаг.



Баян хүн яагаад шийтгэгдсэн бэ?

Нэр нь байхгүй баян хүний тухай Есүсийн өгсөн мэдээллийг авч үзвэл тэрээр 1-рт, баян, 2-рт, үнэтэй хувцас өмсдөг, 3-рт өдөр бүр найрлан цэнгэдэг, 4-рт, том сайхан байртай байсан. 5-рт нас барж оршуулагдсан бөгөөд



Үхэгсдийн оронд орсон. “Үхэгсдийн орон”-г олон хүн “там” гэж ойлгодог ч тийм биш. Ямартай ч, энэ хүн тамд орохоор муу хүн байсныг Есүс дурдаагүй. Түүнийг муу үйлс хийсэн тухай нэг ч үг алга.

Аль эсвэл баян байх нь гэм үү? Үнэтэй сайхан хувцас өмсөх нь нүгэл үү? Тансаг сайхан зоог барих нь зөвт хүний хийж болохгүй зүйл гэж үү? Ингэж дүгнэж зориуд ядуу байхаар шийддэг хүмүүс бий. Гэтэл энэ дүгнэлт буруу. Абрахам, Исаак, Иаков, Иов, Давид зэрэг «Хуучин гэрээ»-ний үед амьдарсан олон зөв шударга хүн Ертөнцийн Эзэний ивээлээр баян чинээлэг байсан. Тиймд энэ баян хүн ердөө “Номлогчийн үгс”-нд хэлсний дагуу (2:24) өөрийн ажил зүтгэлээр олсон баялгийг эдлэн жаргалтай амьдарсан байж таарна. Түүнийг шууд буруутгасан зүйл Есүсийн үгэнд алга.

Гэтэл **“зөв юмыг үйлдэхийг мэддэг хэрнээ үл үйлддэг хүнд энэ нь нүгэл юм”** (Иаков 4:17).



Ядуучуудад туслах талаар «Хуучин гэрээ» номд их юм бичигдсэн байхад баян хүн гэрийнхээ гадаа амь зогоож буй Лазарт хоолны үлдэгдэл өгөхөөс цааш туслаагүй нь түүний буруудсан ганц зүйл. Гэвч хүн хийгээгүй зүйлийнхээ төлөө тамд орвол бид бүгд тамаас зайлсхийх найдвар байхгүй билээ. Ямар нэгэн хийх ёстой сайн зүйлээ хийлгүй өнгөрөөх аюул бидэнд үргэлж нүүрлэж байдгийн хувьд өөрөөсөө хэцүү амьдралтай хүнийг энэрэн туслах ёстой гэж баян хүний сөрөг жишээнээс сурсан ч гэсэн “хэрхэн баян хүн шиг тамд оролгүй, ядуу Лазар шиг диваажинд орох вэ?” хэмээх асуултанд хангалттай хариулт болж чадахгүй билээ.

Лазар яагаад сайшаал хүртсэн бэ?



Тэгвэл Лазарын тухай мэдээллийг эргэн харъя: тэрээр 1-рт, яр өвчинд баригдсан, 2-рт, ядуу, 3-рт, тахир дутуу шинжтэй (хэвтдэг), 4-рт, түүнтэй нохой л хамт байсан, 5-рт, өлсдөг, 6-рт,

баян хүний хоолны хаягдлаас иддэг байсан. (“Ширээнээс унасан өвдөл цөвдлийг нь идэх” гэдгийг шууд утгаар ойлгож болохгүй нь ойлгомжтой. Өөрөөр хэлбэл, баян хүн хоолоо ширээнээсээ унагаагаад Лазар унасныг нь түүж иддэг байгаагүй гэсэн үг.



Улмаар, өвдөл цөвдлөөр насанд хүрсэн хүн хэрхэн амь зуух билээ. Тэгвэл баян хүн үлдэгдлээсээ Лазарт өгдөг байжээ гэж ойлгогдож байна.) 7-рт нас барахдаа Лазар тамд очоогүй, Абрахамын өвөр дээр тавигдан тайтгарал авсан. Лазар яагаад тамд ороогүй талаар бас л мэдээлэл алга. Ертөнцийн Эзэнд хайртай, үнэнч сэтгэлтэй, баян хүний төлөө байнга гуйдаг байсан гэх мэт Лазарын тухай сайшаах зүйлс ерөөсөө бичээгүй. Лазарыг сайшаах юм юу ч байхгүй. Арчаагүй ядуу байх нь буян биш гэдэгтэй та санаа нийлэх биз ээ.

«Хуучин гэрээ»-нд харин ч Их Эзэний тушаалыг дагадаг хүнд баялаг, эрүүл мэнд гэх зэрэг сайн сайхан бүхнийг амласан, харин дуулгаваргүй нэгнийг хоосрол, өвчин зовлон г.м. муу муухай нь дагадаг гэсэн (жишээ нь Дэд хууль 28:11,16, 27,29).

Мөн, “...би үнэнч шударга хүн Мөнхийн Эзэнд хаягдан, үр хүүхдүүд нь гуйлга гуйж байхыг өдий болтол үзээгүй” (Дуулал 37:25, ББ). Тийм бол Лазар шударга хүний хувьд яагаад бусдаас хоол гуйсан байх вэ?

Энэ өгүүллэгийг анх сонссон иудейчүүдийн дунд давамгайлсан «Хуучин гэрээ»-ний ойлголтоор дүгнэхэд баян хүн сайн, харин ядуу Лазар муу хүн байж таарна! Тэгвэл яагаад сайн нь тамд, муу нь жаргалтай газарт очсон нь үнэхээрийн ойлгомжгүй болно.





Хүн жаргах ба зовох ээлжтэй гэсэн ойлголт өгч буй мэт Абрахамын үгийн (25-р иш.) үндсэн дээр дүгнэхэд, хүн амьдралдаа дараах хоёр сонголттой гэж харагдана: 1-рт, одоо Их Эзэнээр ивээгдсэн сайхан амьдралаар амьдраад нас барсан хойноо тамд орж мөнхөд шатах. 2-рт, Их Эзэнээр харагдсан хэцүү амьдралаар яваад үхсний дараа Абрахамтай хамт жаргах. Гэвч ийнхүү дүгнэх нь үнэхээрийн мөхөс, утга учиргүй билээ. Үүнээс гадна энэ дэлхийд ч ихэд баян амьдарсан Абрахамын нөхцөл байдалтай энэ дүгнэлт зөрчилдөж байна.

“Тийм биш, баян хүн Есүсийг өөрийнх нь гэрийн төлөө Загалмай дээр нас барсныг хүлээж аваагүй шүү дээ” гэж маргалдах итгэгч, пастор ч бий.

Тэдгээр хүмүүс Библийн амьд үгийн өрнөсөн он дарааллыг сайтар судлаагүй, хам сэдэвт нь авч үзэлгүй, хайш яайш, хариуцлагагүй ханддагаас ийм хөнгөн хуумгай дүгнэлт гарч байгаа нь маш аюултай үр дагавартай билээ.

Баян хүн Есүсийг нас бараагүй байхад Загалмайн тухай мэдээд татгалзсан байх ямар ч боломж байхгүй (Лук номын 23-р бүлэгт Есүсийн нас барсан тухай гардаг бол энэ өгүүлэл тэрнээс өмнө буюу Лук номын 16-р бүлэгт нь бичигдсэн хэмээн дурдах нь илүүд биз ээ).

“Лазар өөрийнх нь төлөө нас барсан Есүст итгэсэн учраас аврагдсан” гэвэл мөн адил он дарааллын хувьд ташаа болно.




Лазар үхсэн
Баян үхсэн



Ямар ч байсан энэ хоёр хүн яагаад тамд эсвэл диваажинд орсон тухай тодорхой мэдээлэл өгөгдөөгүй байгааг ойлгож авах нь зүйн хэрэг юм. Тамд орохоос зайлсхийж диваажинд орохын тулд юу хийх вэ гэдэг талаар мэдэх нь бидний хувьд хамгийн чухал баймаар байвч энэ талаар тус болохуйц мэдээлэл энд алга.

Абрахамын өвөр гэж юу вэ?

Тэгвэл Лазарын очсон “Абрахамын өвөр”-ийн тухай авч үзье. Шууд утгаар нь ойлгоход тэнгэр элч нар Лазарыг биеэр нь авч Абрахам дээр аваачин өвөр дээр нь суулгасан. Яагаад тэр вэ? Дараа нь нас барсан баян хүн Абрахам болон өвөр дээр нь суусан Лазар хоёрыг харсан. Абрахам өөрөө тэнд бодитойгоор байгаа учраас өвөр нь биеийнх нь бодит хэсэг гэж ойлгогдмоор. Уг нь грек үг нь (G2859) нэг бол биеийн өвөр, нэг бол дээлийн өврийг хэлдэг (Лук 6:38). Хоёрдахь утгаар орчуулвал тэнгэр элчид Лазарыг “Абрахамын (дээлийн) өвөрт хийсэн”. Энэ ч их сонин төсөөлөл болж олон асуултыг төрүүлнэ.



Тухайлбал, тамд орохгүй хүн бүрийг ер бусын элч нар Абрахамын өвөрт аваачдаг уу? Абрахамын өвөр яагаад бусдынхаас илүүд тооцогдох вэ? Хэрхэн энэ өвөрт олон хүн багтдаг вэ? Хүн болгон өвөр дээр нь суухаар Абрахамд хэцүү биш үү?



Нас барсныхаа дараа бид заавал хүний өвөр дээр суух ёстой юу? гэх мэт инээдтэй асуултууд нь “Абрахамын өвөр” шилжсэн утгатай хэллэг л байж таарахыг харуулдаг.



“Аврахамын өвөр”-ийг тайвшралын газар буюу диваажин, тэнгэр дээрх улс, мөнхийн жаргал хэмээх шилжсэн утгаар ойлгох нь түгээмэл. Гэтэл тэнгэр дээрх улсын хамгийн чухал Нэгэн Абрахам бус, харин бидний Их Эзэн Есүс Христ билээ. Хүн диваажинд очихдоо яагаад

Есүсийн өвөр дээр, эсвэл Ер бусын Аавынхаа өвөр дээр суудаггүй вэ? Лазарын очсон газарт Есүс Их Эзэн ерөөсөө харагдахгүй, бүр мэдэгдэхгүй байдаг.

Үүнээс гадна, Лазарыг энэ амьдралд зовсон учраас тэнд “тайтгарч байна” гэсэн нь ямар утга учиртай вэ? Мөнхийн жаргал нь зовлонгийн тайвшрал төдий газар гэж үү? Лазар хүний өвөр дээр сууж буй тухай л дурдагддаг. Тэр нэг ч үг хэлээгүй. Үлэмж их баяр жаргал ундрах газрын шинж тэмдгийг энд өгүүлсэнгүй. Нарийвчлан авч үзэхэд диваажин юмуу тэнгэрийн талаар ч үг дурдагдсангүй.

Абрахам тэнгэрт байгаа эсэх тухайд Библийн бусад хэсгээс авч үзвэл, «Еврей» захидал тодорхой мэдээлэл өгнө. Энэ захидлын “итгэлийн баатрууд” хэмээн нэрлэдэг 11-р бүлгийн дагуу Абрахам



Ертөнцийн Эзэний өөрт нь амласан амлалтыг хараахан хүлээж аваагүй. Зөвхөн Абрахам төдийгүй, тэнд дурдагдсан итгэлийн бүх баатрууд Их Эзэний амласныг одоо хүртэл хүлээж аваагүй байна (11:13, 39-40). Тэгвэл “Абрахамын өвөр” гэдэг нь тэнгэрт буй мөнхийн улсын нэр байж боломгүй юм. Энэ хэллэг юуг хэлдэг вэ? гэсэн асуултын хариу Лукын өгүүллээс тодорхойгүй.



Эртний уламжлалаар бидэнд ирсэн буруу сургаал

Теологичид “*Абрахам, Лазар хоёрын байгаа газар “Үхэгсдийн орны шударга хүмүүсийн хэсэг”, харин баян хүн тус орны муу хүмүүсийн хэсэгт байна*” гэсэн батлагдаагүй тайлбар өгдөг. Гэвч Үхэгсдийн орон хоёр тасагтай хэмээх ойлголт Библийн хаанаас ч олдохгүй. Цаашилбал теологичид: “*Есүс нас барж дахин амилж тэнгэр өөд одохдоо Үхэгсдийн оронд байсан шударга хүмүүсийг тэндээс гарган Тэнгэрийн орон луу авч явсан*” гэж заадаг. Энэ сургаал бол “*Өндөрт дээш гарахдаа, Тэрээр олзлогсдыг дагуулж, хүмүүст бэлгүүд өгсөн*” гэж хэлсэн Эфэс 4:8-т нэмж тайлбар өгснөөс үүссэн.

Гэтэл «Еврейчүүдэд» бичсэн захидал Есүсийг нас барж дахин амилснаас олон жилийн дараа л бичигдсэн бөгөөд тэр хожуу үед ч Абрахам өөрт нь амласныг аваагүй, хүлээдэг хэвээрээ байсныг гэрчилдэг. “*Абрахам мэт Их Эзэнд итгээд нас барсан*



хүмүүс “нас барах ба мөнхийн жаргалд орох хоёрын хоорондох хүлээлтийн байдал”-д байна” гэж мөн заадаг. Гэвч үхлээс бусад хүлээлтийн ийм байдлын тухай ойлголт мөн адил Библид хаана ч байхгүй.

Үхэл яг л гүн гүнзгий нойр мэт байх тухай «Хуучин гэрээ», «Шинэ гэрээ»-ний аль алинд заасан байдаг (Дуулал 13:3, Даниел 12:2. Иохан 11:11-14—т Есүс найз Лазарыгаа “унтсан, гэхдээ би түүнийг нойрноос нь сээрэнэ” гэхэд

дагалдагч нар нь буруу ойлгож “унтсан бол эдгэрнэ” гэдэг. Үүнд Есүс “Лазар нас барсан” гэж шуудхан [=шилжсэн утгаар бус] хэлж өмнөх үгээ тодруулдаг. Үхлийн нойрноос сээрээгдэх гэдэг




нь дахин амилуулагдах гэсэн утгатайг дараах үйл явдал харуулна). Нас барсан хүмүүс өнөө хүртэл булшинд буюу Үхэгсдийн оронд “нойрсож” байна (Иов 3:11-19; Дуулал 6:5; 115:17; Номлогч 9:2-5,10; 1 Коринф 15:20; Исаиа 57:1-2; Данийл 12:2; Үйлс 2:29,34; 13:36). Эцсийн өдөр үхлээс амиллахыг тэд хүлээгээд байгаа нь олон ишлэлд батлагдсан байна (Иохан 6:40; Үйлс 24:15; Илчлэл 20:4-5 г.м.).

Библийн эдгээр бодит баримттай Абрахамын энэ өгүүллэгт харуулсан дүр зураг нийцэхгүй байна. Библийн тодорхой сургаалын дагуу Абрахам диваажинд ороогүй, тэнгэрийн дээрх улсад ч яваагүй, харин нойрсож байгаа юм шиг булшинд хэвтэж байна.



Булш болох Үхэгсдийн оронд хэн ч амьдаар байдаггүй. Тэгвэл “Абрахамын өвөр” гэдэг нь бодитой газрын нэр байх боломжгүй. “Абрахамын өвөр” гэх энэ хэллэг Библийн өөр хаана ч гардаггүй. Мөн тэнгэр элч үхсэн хүнийг диваажин юмуу тэнгэрт аваачдаг төсөөлөл Библийн өөр хаана ч гардаггүй². Абрахам, Лазар хоёр яг хаана байгааг хэлж өгөх өчүүхэн ч сэжүүр алга аа.

Үхлээс амиллах цаг болоогүй байхад...



Лазар нас барахдаа оршуулагдсан эсвэл үхэгсдээс амилсан тухай юу ч байхгүй. Тэнгэр элч нар түүний шарилыг авч яваагүй нь ойлгомжтой. Иймээс “*тэд түүнийг сүнсээр нь авч явсан*” гэж тайлбарладаг багш бий. Гэтэл Абрахамын өвөр дээр очсоны дараа хуруу бүхий бие махбодтой байгаа нь 24-р ишлэлээс харагдаж

байна. Тэрээр дахин амилсан биетэй гэсэн үг мэт.

Гэтэл “нойрсогчдоос анхны үр жимс” буюу “**энэ дэлхийд нас барсан хүмүүсийн дотроос [үхэшгүй амьтай] болж дахин амилсан анхны хүн**” Есүс болох нь бодит баримт билээ (1 Коринф 15:20; АБ, ББ, [хаалтан доторхийг грек эхийн утгын дагуу засав]).

² Матай 24:31-т тэнгэр элч нар Есүсийг эргэж ирэх үед амьд итгэгчдийг энд тэндээс авч Израилын нутагт цуглуулах болно. Энэ нь нас барсан хүнийг тэнгэр дээрх улсад аваачихаас эрс өөр нөхцөл байдалтай.



Есүс Лазарын тухай өгүүлэхдээ Өөрөө нас барж дахин амилаагүй байсныг бид өмнө нь тэмдэглэж авсан. Мөн, **“Христ бол анхны үр жимс юм. Дараа нь Христийн хүмүүс Түүнийг ирэхэд амилуулагдана”** (1 Коринт 15:23). Есүс дахин иртэл Түүний хүмүүс дахин амилахгүй гэсэн үг. Лазар тэгвэл яаж итгэлийн баатруудаас бүү хэл, *Есүсээс өмнө* амжиж биеэрээ дахин амилж диваажинд очиж чадсан бэ? гэсэн зөрчил гарч ирээд байна. Энэ боломжгүй зүйл.

Үүнээс гадна Есүс Өөрөө **“Тэнгэрээс доош бууж ирсэн Хүний Хүүгээс өөр тэнгэрт дээш гарсан хүн нэг ч үгүй”** хэмээн гэрчилсэн (Иохан 3:13).³ Давид хаан лав тэнгэрийн улсад очоогүйг Петр Есүсийг тэнгэр одсоны дараа “итгэлтэйгээр” баталсан (Үйлс 2:29,34). Бусад итгэлийн баатрууд мөн адил (Еврей 11). Лазар тэгвэл яаж булшийг алгасаад тийш очсон болж таарах вэ? Боломжгүй. Энэ өгүүллэг Есүсийн амнаас унасан үед Лазар гэгч хүн, Абрахам ч, өөр ямар ч хүн үхэгсдээс амилаагүй, тэнгэр дээш гараагүйг дээрх ишлэлүүд тод томруун үгээр баталж өгдөг. Үүнийг эсэргүүцвэл Есүсийн үгийг, тэр ч байтугай Библийн хамаг сургаалыг үгүйсгэж байгаатай адил юм.

³ “Тэнгэрээс доош бууж ирсэн, *одоо тэнгэрт байгаа* Хүний Хүүгээс өөр тэнгэрт дээш гарсан хүн нэг ч үгүй” гэж орчуулдаг олон орчуулга бий. Эртний грек эх бичигт хүний яриаг тэмдэглэдэг тэмдэг байдаггүй. Иймд Есүсийн Никодемтэй хийсэн ярилцлага 12-р ишлэлд дууссан бөгөөд 13-р ишлэлээс эхлэн тэр бүлгийн үлдснийг Иохан МЭ 1-р зууны сүүлийн үед буюу Есүс аль хэдийнэ тэнгэрт одсоны дараа Ариун Сүнсний амьсгалснаар бичсэн гэж үзэх боломжтой. Тэгвэл хэн ч өнөөдөр тэнгэрт дээш гараагүй нь бүр ч их батлагдаж байна.



Их Эзэний үгийг яг энэ зүйл дээр эсэргүүцдэг хүмүүсийн талаар Паул нас барахаасаа өмнөхөн бичихдээ: **“Тэд одоо үнэн сургаалаас хазайж холдоод нас барсан хүмүүсийг Ертөнцийн Эзэн аль хэдийн амилуулсан мэтээр ярьцгааж явна. Түүгээрээ тэд зарим нэгэн хүмүүсийн итгэлийг самууруулан төөрөгдөлд оруулаад байгаа юм. Гэхдээ Ертөнцийн Эзэний үнэн сургаал нь их барилгын хөдөлгөөнгүй бат суурь мэт өөрчлөгдөшгүй...”** (2 Тимот 2:18-19, ББ).

Үхэгсдийн оронд хүн сэхээгүй байхад баян хүн тэнд хэрхэн тамаа үзэх боломжтой вэ?

Баян хүн нас барж оршуулагдсаныхаа дараа Үхэгсдийн оронд орж галын дөлд тарчилдаг гэж Есүс яриагаа үргэлжлүүлдэг. Мөнхийн зовлонтой тамд



итгэдэг хүмүүсийн үзлээр энэ баян хүн нас барсан өдөртөө л тамд орж одоогоор 2000-гаад жилийн турш тэнд халуун дүрэлзэх түймэрт шарж, шатсаар л байж, яг одоо тарчлан

орилж байгаа. Гэтэл энэ өгүүллэгт “там” гэдэг үг байхгүйг анхаарах нь чухал. Баян хүн оршуулагдсаны үр дүнд *Үхэгсдийн оронд* байсан (23-р ишлэл). Үхэгсдийн орон там хоёрыг нэг л газар гэж боддог хүмүүс олон.



Гэтэл «Хуучин гэрээ»-ний сургаалыг шинжиж үзэхээр Үхэгсдийн орон ердөө л булш буюу үхмэл байдлыг хэлдэг. (“Баян нь ч үхсэнд түүнийг оршуулав. Тийнхүү баян байсан хүн Үхэгсдийн оронд... байхдаа...” гэдэг 22-23-р ишлэл ч үүнийг харуулж байна.) Ертөнцийн Эзэний Үгийн дагуу Үхэгсдийн оронд буй нас барагсад юу ч мэдэхгүй, юу ч санан дурсахгүй, юу ч төлөвлөдөггүй, юу ч хийдэггүй, юу ч ярьдаггүй, хэнийг ч үзэн ядах юмуу хайрладаггүй, түнэр харанхуй нам гүмд байдаг (Номлогчийн үгс 9:5-6, 10 г.м.).



Ихэнх хүмүүс Библийн энэ тодорхой үгэнд биш, хүний сэтгэлийн үхэшгүйд итгэдэг учраас нас барагсад сэтгэл, сүнсээрээ тамд ордог гэж үзнэ. “Тамд буй хүмүүс ямар ч хайр сэтгэлгүй болж, сайн сайхан зан чанар бүхнээ алддаг” гэж заадаг пасторууд ч бий. Үхэгсдийн “хайр мөхдөг” нь үнэн. Гэтэл тэдний хорсол, атаа жөтөө адилхан мөхдөг (Номлогчийн үгс 9:6). Тэдний муу муухай зан чанарууд адилхан үгүй болно гэсэн үг.

Библийн дагуу хүний амин сүнс биш, сэтгэл нь Үхэгсдийн оронд ордог учраас тэр (Дуулал 16:10; 86:13 г.м.). Үхэгсдийн оронд орсон сэтгэл ул мөргүй алга болдог. Иймд, “**[Хүний] сүнс гарч явдаг бөгөөд тэрээр газар шороо уруу буцдаг. Яг тэр өдөр түүний бодлууд мөхдөг**” (Дуулал 146:4).



Энэ ишлэлд цогцос юмуу бие махбод дурдагдаагүй нь анхаарууштай, хүн өөрөө эргээд шороо болж хувирдаг. Хүн өөрөө бодохоо больдог. Бодох чадвар хүний дан сүнсэнд нь байхгүйг энэ ишлэл тод харуулдаг. Амин сүнс нь гарч явахад хүн нь амьсгал хурааж амьгүй болдог (“сүнсгүй бие үхмэл байдаг” Иаков 2:26). Амин сүнс бол амь нь бөгөөд амь нь гэсэн үг. Харин бодох, сэтгэх, ухамсартай байх чадварууд сэтгэлд оршдог.⁴

Гэвч мөнөөх баян хүн Үхэгсдийн оронд ч гэсэн харах нүдтэй, бодох тархитай, ярих амтай, хатсан хэлтэй, өвдөлт мэдрэх мэдрэлтэй. Баян хүний сэтгэлийн хөдөлгөөн, бодох сэтгэх чадвар нь арилаагүй. Үгнээс нь муу ч, сайн ч зан чанар нь мэдэгддэг. Тэрээр юуны өмнө өөрийгөө бодсон ч, Лазарыг зарахаас санаа зовохгүй ч гэсэн, таван дүүгээ ч марталгүй хайрлан өрөвдөж, аюулгүй байдалд нь санаа тавьж, тэднийг аврах хүсэлтэй байгаа нь гайхал төрүүлэхгүй гэж үү! Баян хүн нас барж оршуулагдсан байж хэрхэн бие махбодтой, сэтгэлтэй ер нь амьтай байж чадах вэ?

⁴ Хүчилтөрөгч, устөрөгч хоёр нэгдэх урвалын үр дүнд ус хэмээх нийлмэл бодис үүсгэдгийн адилаар амин сүнс бие махбодтой нэгдсэнээс сэтгэл үүсдэг (Эхлэл 2:7). Амин сүнс бие махбодиос эргэж салахад сэтгэл буюу юм бодох, мэдрэх, сэхээтэй байх чадвар нь мөхөн устдаг. Амьсгал хураасан хүнийг еврейгээр “үхсэн сэтгэл” гэдэг (Левит 21:11; Тооллого 6:6 г.м.). «Хуучин гэрээ»-нд нас барсан хүнийг буюу шарилыг нь 13 удаа еврей эхэнд “сэтгэл” гэдэг үгээр тодорхойлсныг монголоор “үхсэн хүн”, “үхэгсэд”, “хүний цогцос”, “хүүр” гээд утгаар нь орчуулж тавьсаны улмаас биетэй нь хамт сэтгэл үхсэн нь харагдашгүй болсон. Энэ бүхнээс харахад, хүн биегүй сэтгэл болж үргэлжлүүлэн амьдрах огт боломжгүй хэрэг.



Баян хүн үхэгсдээс амилсан юмуу? Хүний булшийг нээгээд үзэхээр ялзарч буй бие нь тэнд байж л байдаг шүү дээ. Үхлээс амилах нь болоогүй гэсэн үг. Үхсэн хүн тэгвэл булшинд ялзардаг, тамд шаналдаг хоёр биетэй болох уу? Мэдээж үгүй.

Зарим христчин багш нар дээрх Дуулалын дагуу хүний сүнс гарч явдаг учраас *“тамд байгаа хүмүүс биеэрээ биш, сүнсээрээ шатан зовж байгаа”* гэж тайлбарладаг. Энэ нь бас тэдний шатаж дуусдаггүйн шалтгаан гэнэ.

Шууд, шилжсэн аль ч утгаар хийгдээгүй ийм утгын тайллыг “сүнслэгжүүлсэн тайлбар” гэж нэрлэдэг. Гэтэл сүнс хэрхэн бодит галд шатах вэ? Сүнсэнд дусал ус яаж нэмэр болох вэ? Хамгийн гүн ангал хүртэл сүнсэнд саад болж чадна гэж үү? Эсвэл энэ бүх зүйлийг мөн л “сүнслэгжүүлсэн утгаар” хүлээж авах ёстой юмуу? “Сүнсний гал”, “сүнсний ус”, “сүнсний ангал” гэж юу байж болох вэ? “Сүнсний ус” гэдэг Ариун Сүнснийг хэлж магад (Иохан 7:38-39). Гэтэл Лазар яаж “сүнслэг хуруу”-гаа Ариун Сүнсэнд дүрэх вэ дээ. Ариун Сүнс гол мөрөнтэй зүйрлэгдсэн болохоос дусал дуслаар тараагдахгүй.

Ертөнцийн Эзэний сүнслэг үнэн бол сүг сүүдрийн хий үзэгдэл биш, харин бодит чанартай. Тэрээр бидэнд Үгээ нэг бол шууд утгаар, нэг бол шилжсэн утгаар хэлдэг. Дээрх “тайлбар”-ыг эргэцүүлэн бодвол үнэн хэрэгтээ юу ч тайлбарлаж өгдөггүйг олж харна. Библийн үгийг “сүнслэгжүүлэх” нь хий явж, хий уймруулам будилаанд л хүргэх, дур мэдсэн хэрэг учраас тэр.



Ингэх нь үр дүнгүй сэлгүүцэн төөрөгдөлд оруулахаас цаашгүй учраас сүнслэгжүүлэлт тайлбараас бид зайлсхийх хэрэгтэй.

Дээр иш татсан Дуулал 146:4-ын дагуу хүний амин сүнс биеэс нь салах мөчид

бодох чадвар нь үгүй болдог. Баян хүн Абрахамын адил бодох чадвартай байх нь тэднийг хоёулаа дан сүнсээрээ орших боломжгүйг харуулж байна. Үнэндээ энэ өгүүлэгт амин сүнсийг огт дурдаагүй байна. Харин хараатай нүд, хатсан хэл гээд бодитой биеийн хэсгүүдээс гадна сэтгэлийн чадварууд дурдагдсан. 24-р ишлэлд “амь тэмцэж” буй баян, амьтай л болж таарна. Нас барсан баян хүнд нас барагсдын шинж нэг ч алга. Тэрээр хэрхэн булшинд амьтай сэхээтэй, тарчлан зовох чадвар бүхий биетэй болсон нь огт ойлгомжгүй билээ.

Хүн шүүгдээгүй байж шийтгүүлж болох уу?

Мөнөөх баян хүн хэзээ шүүлтэнд орж тамлуулах ял авсан бэ? гэдэг асуулт зүй ёсоор тавигдаж байна. Хүнийг шүүхгүйгээр шийтгэх нь ёс бусын хэрэг болох тал дээр хүн бүр санаа нэгднэ. Хэрэв энэ баян, шүүлтэнд оролгүйгээр шийтгүүлж байгаа юм бол Ертөнцийн Эзэн түүнд шударга бусаар хандсан болж таарна. Харин Ертөнцийн Эзэн туйлын шударга болохыг бид мэдэх учраас тэгэх нь боломжгүй хэрэг.



Энэ өгүүллэгт баян хүний хийсэн хэрэг дурдагдаагүй-гээс гадна шүүлтийн тухай нэг ч үг алга. Шийтгэл гэдэг үг ч дурдагдаагүй.

Цааш бодоход, хэрэв муу хүмүүс нас барангуутаа тамд орж, муу үйлсийнхээ шийтгэлийг аль хэдийнээ авч эдлээд байгаа юм бол дахин амилахын хэрэг юу вэ? Ямар учраас хожим Христийн цалин цагаан сэнтийн өмнө болох шүүлтэд орох ёстой вэ? гэсэн том асуудал урган гарна (Илчлэл 20:11-15).

Матай 10:15 ба 12:41-н дагуу Есүсээс олон зуун жилийн өмнө амьдарсан, эртний Содом, Ниневе хотынхон Түүнийг сургаалаа заах үед шүүлтэнд ороогүй л байсан. Шүүлт явуулах тодорхой нэгэн өдрийг Их Эзэн тогтоосон бөгөөд тэр л өдөр тэд үхлээс амилах болно (Үйлс 17:31-32).



Ингээд муу хүмүүс ч гэсэн заавал биеэрээ амилахыг Библид баталсан байна. **“Булшинд байгчид бүгдээрээ Түүний [=Есүсийн] дууг сонсон, гарч ирэх цаг ирж байна. Сайныг үйлдсэн нь амийн амилалд, муу муухайг үйлдсэн нь ялын амилалд байх болно”** (Иохан 5:28-29).

Есүс Христ үхлээр нойрсож буй бүх хүмүүсийг ирээдүйд сэрээх нь тодорхой. Түүнийг *өнөө үеийн эцэст* энэ дэлхийд эргэж ирэх үед Өөрийнх нь хүмүүс болох итгэгчид “амийн амилал”-аар үхэгсдээс амилах болно (1 Коринт 15:23; Иохан 6:39,40,44,54).



Тэгээд Түүний Хаант Улс мянган жил үргэлжлээд төгсөхөд итгэгч бус хүмүүс “ялын амилал”-аар амилаад Есүс Христийн залран суух Цалин цагаан сэнтийн өмнө шүүгдэх болно (Илчлэл 20:7,11). Энэ бүхнээс харахад шүүлт хүний нас барсан даруйд болохгүй. Ертөнцийн хамгаас шударга Эзэн хэзээ ч шударга бус зүйл хийхгүй нь лавтай (Эхлэл 18:25). Шударга шүүлт явуулах өдрийг Тэрээр тогтоосон байна. Баян хүний ч үхлээс амилж шүүлтэнд орох цаг нь болоогүй гэсэн үг.

Дүгнэж хэлэхэд, баян хүн үхлээс амилаагүй ч бие махбодтой, шүүлтэнд ороогүй ч шийтгүүлж буй мэт байхад түүний яг хаашаа орсон, яагаад тарчилж байгаа нь тодорхойгүй хэвээр байна. Үхлийн булш болох Үхэгсдийн оронд орсон гэхэд тэрээр бүх юмаа санадаг, мэдээ сэхээтэй, бас зовж чадах биетэй байгаа учир тайлагдахын аргагүй. Лазар ч мөн адил яг хаашаа очсон, яагаад тайвшруулж байгаа нь тодорхойгүй. Есүсийн ярьсан өгүүллэгийн нөхцөл байдал харин ч Библийн олон үнэнтэй нийцэхгүй нь харагдаж байна.

“Боломжтой бол шууд утгаар нь ойлгож ав” гэсэн зарчмын дагуу дүгнэхэд энэ өгүүллэг болсон явдал байх боломжгүй.

Гэхдээ энэ сэдэв дэндүү чухал учраас дөнгөж талдаа орсон өгүүллэгээ үргэлжлүүлэн шинжих хэрэгтэй. □





Баян хүн, Абрахам хоёрын дунд өрнөсөн яриа тус өгүүллэгийн маш чухал хэсэг. Дараагийн нийтлэлд тэр хоёрын яриаг авч үзэх болно.

Ашигласан эх сурвалж:

- Ариун Библи (2004; 2013; 2019). Улаанбаатар: Ариун Бичээс Нийгэмлэг. Энэ судалгаанд АБ гэж товчилсон. Өөрөөр тодорхойлоогүй бол «Шинэ гэрээ»-ний ишлэлийг энэ орчуулгаас авсан байх болно.
- Библи (2015). Улаанбаатар : Монголын Библийн Нийгэмлэг. Энэ судалгаанд ББ гэж товчилсон.
- Brown, C. (1975). The New International Dictionary of New Testament Theology.
- Bullinger, E. W. (1902). The Rich Man and Lazarus: An Intermediate State? <http://www.biblical-data.org/LAZARUS.pdf> -оос олсон.
- Dawson, S. G. (1943). The rich man, Lazarus, and the afterlife. www.truthaccordingtoscripture.com -оос олсон.
- Eby, J. P. (n.d.). Abraham's bosom: A treatment of the parable of the rich man and Lazarus. <https://godfire.net/eby/abrahams.html> -оос олсон.
- Froom, L. E. (1966). Gravity of Ascribing False Teachings to Christ. www.truthaccordingtoscripture.com -оос олсон.
- Gill, John (1690-1771). Exposition of the Entire Bible. www.biblehub.com хэмээх сайтаас олсон.
- Huie, B. T. (1998). Lazarus and the rich man. www.tentmaker.org -оос олсон.
- Leiter, S.Y. (2003). Grasping the Heel of Esau. www.chabad.org хэмээх сайтаас олсон.
- Martin, E. L. (2003). The real meaning of Lazarus and the rich man. <http://www.what-the-hell-is-hell.com/HellArticles/RichManParable.htm> -оос олсон.
- Smith, L. R. (n.d.). Lazarus and the Rich Man: A scriptural journey through the intriguing parable of Lazarus and the rich man. www.bible-truths.com -оос олсон.
- Стандарт Монгол Орчуулгын апп (2023). Энэ судалгаанд СМО гэж товчилсон. Өөрөөр тодорхойлоогүй бол «Хуучин гэрээ»-ний ишлэлийг энэ орчуулгаас авсан байх болно.
- Patching, J. The rich man and Lazarus.



Баян хүн, ядуу Лазар хоёрын тухай өгүүллэг I • 22

<http://www.tentmaker.org/books/RichManandLazarus-Patching.html> -оос олсон.

-Strong, J. (1890). Strong's exhaustive concordance of the Bible (with Greek and Hebrew Lexicons). www.blueletterbible.org хэмээх сайтаас олсон.

-Wilson, Larry (2007). The rich man and Lazarus. Wake up America Seminars. www.wake-up.org -оос олсон.

-Witherell, J. F. (1843). Rich man and Lazarus. In *Five Pillars in the temple of partialism removed*. Concord: Balm of Gilead.